



## БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

### ИЛТГЭХ ХУУДАС

2024 оны 15 сарын 22 өдөр

Дугаар 31

Номгон

Байгууллагын 2023-2024 оны 1 дүгээр улирал хүртэлх хугацаанд ТҮ ажилд томилогдсон албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулсан эсэхэд дотоод хяналт хийсэн тухай

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Дотоод хяналт шалгалтын ажлын хэсгийн 2024 оны төлөвлөгөөний дагуу 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр байгууллагын 2023-2024 оны 1 дүгээр улирал хүртэлх хугацаанд төрийн үйлчилгээний албан тушаалд томилогдсон албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулсан эсэхэд дотоод хяналт шалгалтыг зөвлөлийн гишүүн Ж.Лхамдулам хийж гүйцэтгэлээ.

Шалгалтаар 2023 онд хийсэн хөдөлмөрийн гэрээг архивын баримтаас үзэхэд Ж.Дэмчигжав, Я.Дамдинсүрэн, А.Мөнхцэцэг, С.Должинсүрэн, Д.Энхчимэг, Ц.Шүрэнцэцэг, Э.Гандэлгэр, Б.Батзориг, М.Батзаяа нартай байгуулсан нийт 9 гэрээ архивт байна.

Дугаарлалтаас хараад А.Мөнхцэцэг, С.Должинсүрэн нарын гэрээний дугаар давхардсан буюу хоёулаа 3 дугаартай.

Гэрээний дугаарууд дэс дарааллаар нь дугаарлаагүй. Жишээ нь М.Батзаяатай байгуулсан гэрээ нь 16 дугаартай. Дугаар алдаж дугаарласан эсвэл энэ хооронд гэрээ дутуу байгаа мэт харагдаж байна. Энэ талаар хүний нөөцийн мэргэжилтэн Т.Сандагдоржоос тодруулахад 2023 онд үүнээс өөр гэрээ байхгүй гэж хариулсан. Төрийн архивын тасагт 2023 оны 11 дүгээр сард ажилд томилогдсон Сайнхүүгийн Гантуяатай хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй. Үүнээс болж ажилд томилогдсон сард нийгмийн даатгал төлөгдөөгүй тасарсан асуудлаас болж 2024 онд ажил олгогч ажилтан хоёрын хооронд үл ойлголцол үүссэнийг хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс шийдвэрлэн ажилласан.

Харин 2024 онд Б.Энхзаяа, Э.Болормаа, С.Наранцацрал, Э.Гандэлгэр, О.Цэвээн гэсэн нийт 5 хүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна. Хөдөлмөрийн гэрээний дугаарлалтын хувьд мөн алдаатай.

Ажил олгогчийн төлөөлөгч хүний нөөцийн мэргэжилтний хувьд шинэ ажилтанд ажлын байр болон албан өрөө, техник тоног төхөөрөмж, хэлтэс тасгийн

642432050

үйл ажиллагааны чиглэл, алба хаагчидтай танилцуулах, албан тушаалын тодорхойлолт аюулгүй ажиллагааны заавар зөвлөгөө, архивын баримт бичиг байгууллагын дотоод журам, хамтын гэрээ, бусад холбогдох хууль дүрэм журмуудтай танилцуулж ажиллах чиг үүргийг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нь тусгаж хөдөлмөрийн гэрээг байгуулан томилсон шийдвэрийг хэрэгжүүлж үр дүнд хяналт тавин ажиллах нь зүйтэй гэж үзэж байна. Тус ажлыг сард 14 удаа заавал зохион байгуулдаг хэвшил болсон ажил болгох нь зүйтэй.

Хөдөлмөрийн гэрээтэй холбоотой 2024.05.17-нд ажилтнуудаас асуулга авахад:

Шинэ ажилтанд хөдөлмөрийн гэрээний талаар танилцуулах, хамтран ажиллах, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах асуудал сул тодорхойгүй.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн болон холбогдох мэдлэг олгох сургалтад хамруулах нь бага.

Зарим тохиолдолд хөдөлмөрийн гэрээний хувийг ажилтанд өгч гарын үсэг зуруулдаггүй. Хөдөлмөрийн гэрээ хийсэн. Цаашид хэзээ сунгах талаар бүртгэл хөтөлдөггүй.

Хөдөлмөрийн гэрээний нэг хувь ажилтанд өгөөгүй.

Хөдөлмөрийн гэрээнд ажилтанд олгох цалин хөлсний хэмжээг тоогоор илэрхийлэн тодорхой бичдэггүй

Ажилтанд ажлын хувцас хамгаалах хэрэгсэл, хор саармагжуулах бүтээгдэхүүн олгодоггүй зэрэг асуудлууд хөндөгдөн гарсан.

Иймд цаашид хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулаагүйгээс болж ажилтны хувьд хуулиар тогтоосон хууль зүйн нийгмийн хамгаалалт түүнд үйлчлэхгүй. Харин ажилтны хувьд хууль зүйн хариуцлага хүлээх үндэслэл болдог учраас хөдөлмөрийн гэрээг тухай бүр байгуулж байх шаардлагатай. Мөн ажилтан ажил олгогч хоёрын хооронд маргаан гарсан тохиолдолд буруу дутуу, цаг хугацаандаа бүрэн гүйцэт хийгээгүй хөдөлмөрийн гэрээ нь хүчинтэй байдлаа алдах гэсэн эрсдэлүүдтэй байдаг. Үүнийг анхаарах шаардлагатай байна.

ХЯНАСАН:

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

Л.МАНДАЛ

Ж.ЛХАМДУЛАМ



0324020016  
ТУ34247 9007342